

"Эрдэнэдийн ДЦС" ТӨХК-ийн 2023 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

/маягт 2/

<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>			
Тайлагнах хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>"Эрдэнэтийн ДЦС" ТӨХК УБГД:000141004 ҮЦКод: Утасны дугаар:7035-0951</p>		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Дулаан, цахилгааны эрчим хүч үйлдвэрлэх, Дулааны эрчим хүч түгээх, Дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	194474567 ширхэг		
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Б.Зулцэцэг Хянасан: Гүйцэтгэх захирал Б.Бат-Эрдэнэ</p>		
1. Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
	Үзүүлэлт /төг/	2023.01.01	2023.06.30
Санхүүгийн тайлан	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгө	8,738,931,059.11	9,569,411,601.78
	Эргэлтийн бус хөрөнгө	88,417,836,934.25	86,320,913,801.77
	Нийт хөрөнгийн дүн	97,156,767,993.36	95,890,325,403.55
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	12,264,270,016.39	9,363,165,813.34
	Урт хугацаат өр төлбөр	1,397,443,924.72	1,397,443,924.72
	Эздийн өмчийн дүн	83,495,054,052.25	85,129,715,665.49
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	97,156,767,993.36	95,890,325,403.55	
Орлогын тайлангийн үзүүлэлт	Үзүүлэлт	2023.01.01	2023.06.30
	Борлуулалтын орлого /цэвэр/	61,343,644,109.51	40,112,930,442.71
	Борлуулалтын өртөг	60,512,421,055.00	34,751,991,264.66
	Нийт ашиг (алдагдал)	831,223,054.51	5,360,939,178.05
	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	(3,331,984,110.05)	1,656,150,979.79
	Орлогын татварын зардал	329,641,996.67	21,489,366.55
	Татварын дараах ашиг /алдагдал/	(3,661,626,106.72)	1,634,661,613.24
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	1,677,640,346.34
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Орлогын нийт дүн	(3,002,342,113.38)	1,677,640,346.34	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	2023.01.01	2023.06.30
	Өмч	19,447,456,792.53	19,447,456,792.53
	Хөрөнгийн дахин үнэлгээний	59,135,050,898.37	59,135,050,898.37
	Эздийн өмчийн бусад хэсэг	20,937,713,000.00	20,937,713,000.00
	Хуримтлагдсан ашиг	(12,336,490,531.93)	(14,390,505,025.41)
Нийт эздийн өмчийн дүн	87,183,730,158.97	85,129,715,665.49	
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2023.01.01	2023.06.30
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,656,700,708.10	3,830,982,882.99
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	(4,890,697,209.68)	(3,898,572,258.85)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(233,996,501.58)	(67,589,375.86)

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	309,549,506.35	75,553,004.77
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,553,004.77	7,963,628.91

2. Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт

Дүгнэлт:

2023 оны эхний хагас жилийн зорилтот түвшинд 4,122.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар батлагдсаныг тайланд хугацаанд 1,634.7 сая төгрөгийн ашигтай ажиллаж, тайлант үеийн батлагдсан төлөвлөгөөт алдагдлыг 5,757.6 сая төгрөгөөр бууруулан ажилласан байна.

Ашигтай ажиллахад орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулсан нь ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

Цаашид авах арга хэмжээ:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээгээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлтийг үзүүлэлт бүрээр ханган ажиллах, төлөвлөөгүй хөрөнгө, зардал санхүүжүүлэхгүй байх.

3. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт

3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн түвшин 4.1% Өмчийн өгөөж -1.6% Хөрөнгийн өгөөж -1.5% Борлуулалтын ашигт ажиллагаа 15.4%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 1.02 Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 0.26 Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 0.13
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	Төрийн зохицуулалттай үнэ тарифыг мөрддөг.
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, үйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодлого бодох бүртгэлийн бодлого	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, үйлгээ байхгүй

4. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/- байхгүй

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

Төлөөлөн удирдах зөвлөл, түүний үүрэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр Компанийн тухай хууль болон Компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоомж хувьцаа эзэмшигчдээс олгосон эрх ашигт бүрэн нийцсэн шийдвэр гаргаж биелэлтэд хяналт тавьж ажиллах үндсэн үүрэгтэй.

ТУЗ-ийн хороод

ТУЗ-ийн дэргэд тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 хороодтой ба эдгээр хороод нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болгох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам", "Хороодын ажиллах журам"-аар тус тус зохицуулдаг.

ТУЗ нь дараах хороодтой:

- *Нэр дэвшүүлэх хороо
- *Цалин урамшууллын хороо
- *Аудитын хороо

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28-д зохион байгуулагдсан. Тус хурлаар 8 асуудал хэлэлцэн шийдвэр гаргасан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны эхний хагас жилд Эрчим хүчний сайдын удирдамжуудын дагуу 9 удаа ирц бүрдүүлэн хуралдаж, нийт 29 асуудал хэлэлцэж, 23 тогтоол, 4 хураангуй тэмдэглэл, 9 хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлээр компанийн гүйцэтгэх удирдлагын багт үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл өгч ажилласан.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

ТУЗ-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар компанийн Санхүү эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч хавсран ажиллаж байна.

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Бямбажав овогтой Бат-Эрдэнэ

Албан тушаал: “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:/Б.Бат-Эрдэнэ/

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл баталж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Баттулга овогтой Ганчимэг

Албан тушаал: “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн ТУЗ-ийн НБД

Гарын үсэг:/Б.Ганчимэг/

Огноо: 2023.08.29